

ДУНДГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
СУРГУУЛИЙН ЖИЛИЙН СҮҮЛИЙН ХАГАС II ҮЕИЙН ТАЙЛАН

2020.11.17

Мандалговь хот

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/416 дугаар “ 2020 оны сургуулийн жилд сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай” тушаалын хавсралтаар батлагдсан Онцгой байдлын байгууллагын 2020 оны сургуулийн жилийн удирдамж болон Онцгой байдлын албаны сургалтын бодлого, бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах ерөнхий журамд нийцүүлэн газрын даргын 2020 оны А/04 дүгээр “ Сургалт зохион байгуулах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтаар 2020 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан баталсан.

Алба хаагчдын цэргийн хэргийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор *"Монгол Улсын цэргийн нийтлэг дүрэмүүд"*-ээр танхимын 16, дадлагын 16 цагийн сургалтыг явуулж, “Дүрэмч, жагсаалч хамт олон аяныг зохион байгууллаа.

Аюулгүй байдал, эрх зүйн үндэс

Нийт Бүрэлдэхүүнд “ Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль шинэчилсэн найруулга, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, Өргөдөл, гомдол гаргах, түүнийг хүлээн авах, шийдвэрлэх журам, Монгол улсын их хурлын 2019 оны 20 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 38 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2019 оны 5, 6, 8 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 105 дугаар тушаал, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, төрийн албаны зөвлөлийн дарга нарын 2019 оны 36/32 дугаар тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/86 дугаар тушаал, Сэтгэл зүй, сэтгэл заслийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам , Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын “эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сан”-г ашиглах журам, Албаны шалгалт зохион байгуулах журам ОБЕГ-ын даргын 2020 оны А/120 дугаар тушаал, Онцгой байдлын байгууллагын “Объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх журам”, Онцгой байдлын байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах журам, Гэрийн тусгаарлалт, ажиглалтад байгаа иргэдийн хяналтыг

зохицуулах түр журам, Тусгаарлах ажиглах байранд ажиллах алба хаагчдын чиг үүрэг, ДХИС-ийн бакалаврын элсэлтийн журам 2020 оны А/39 дүгээр тушаал, Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх заавар” сэдвүүдээр 38 цагийн сургалтыг тус тус зохион байгуулж, даврахдсан тоогоор 312 офицер, 1170 ахлагч бүрэлдэхүүнийг тус тус хамруулсан.

Эрүүл мэнд-сэтгэл зүйн бэлтгэл

Эрүүл мэнд-сэтгэл зүйн хичээлийн хөтөлбөрийн дагуу “Өвчлөлөөс сэргийлэх арга, Халдварт бус өвчнөөс сэргийлэх эмнэлгийн анхны тусламж, Анхнын тусламж, Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, Сэтгэл зүй, Мансууруулах бодисын хор нөлөө” сэдвүүлээр 10 удаагийн 18 цагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 98 офицер, 385 ахлагчийг тус тус хамрууллалаа.

Ёс зүйн хүмүүжил

“Ёс зүйн алба” нь алба хаагчдын албаны бэлтгэл, бэлэн байдал, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, ёс зүйн дүрэм, журам сахиулж ажиллалаа. Ёс зүйн албаны дүрэм, журам зөрчсөн болон өгөгдсөн үүрэг даалгавар биелүүлээгүй хувцасны зөрчил заагдсан 28 алба хаагчийн сахилга ёс зүйн хяналтын хуудсыг цоолж, 7 алба хаагчдад тушаалаар арга хэмжээ авлаа.

Нийт бүрэлдэхүүнд “Хувь хүний ёс зүй, төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн” сэдвүүдээр 6 цагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 127 алба хаагчдыг хамруулсан.

Үндэсний өв соёл, ёс заншил, дэг жаягийг таниулах, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор алба хаагчдын дунд “Бэсрэг наадам”-ыг 2 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Тус наадам хүчит бөхийн барилдаан, дэмбээний тэмцээн, шагай хамах, үндэсний хувцастай алба хаагч шалгаруулах зэрэг төрлүүдээр зохион байгуулагдаж багийн дүнгээр ахмад Г.Шинэбат захирагчтай 4 дүгээр багийн хамт олон тэргүүлээ.

Гэр бүлийн гишүүдийн эрх үүрэг, хосууд бие биенээ хүндэтгэж, гэр бүлийн үүрэг хариуцлагаа ухамсарлан бат бэх гэр бүлийг бий болгох, үр хүүхдээ сайн хүмүүжүүлж, үнэнч шударгаар ажиллаж амьдрах, өвөг дээдсээ хүндлэх, өв уламжлалыг даган зөв

төвшин гэр бүл болгох зорилгоор Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран тус газрын 6 алба хаагчдын гэрлэлт батлуулах арга хэмжээг зохион байгуулж, хүндэтгэл үзүүллээ.

Ахлагч бүрэлдэхүүний сургалт:

Ахлагч бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх дадлага сургалтыг 15 удаа 24 цагийн хугацаатай “ Төрийн албаны тухай хууль, Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, Аврах ажиллагааг хэрхэн зохион байгуулах, Цаг агаарын хүнд нөхцөлд эрлийн ажиллагааг явуулах, амьсгалын бие даасан төхөөрөмж дээр ажиллах, харилцаа ба хандлага, хуримтлал үүсгэх, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зааварчилгаа” зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 630 ахлагчийг хамруулан мэдлэг чадварыг дээшлүүлэн ажиллалаа.


Биеийн тамирын бэлтгэл:

Бие бүрэлдэхүүний биеийн тамирын хичээлийг спорт зааланд 25 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 750 алба хаагч, ажилчдыг хамруулсан.

Илүүдэл жинтэй алба хаагчдын биеийн жингийн индексийг хангуулах зорилгоор 13 алба хаагчийг хяналтад авч цагийн хуваарийг гарган бялдаржуулах танхимд бэлтгэл хийлгэж байна. Мөн бүрэлдэхүүнийг даваа, баасан гараг бүр гүйлт гимнастик хийж хэвшүүлсэн.

Алба хаагчдын бие бялдрын стандартыг "Цэргийн алба хаагчдын бие бялдрын стандарт"-ын "Өндөр, жингийн зохистой харьцааг тодорхойлох хүснэгт, "Бүсэлхийн зохистой харьцааг тодорхойлох хүснэгт", "Бүсэлхийн зохистой харьцааг тооцох аргачлал", бүсэлхий, ташааны тойргийг хэмжих аргачлалыг үндэслэн тус тус тодорхойлоход тус газрын нийт 72 алба хаагч хамрагдахаас жирэмсний амралттай -2, сургуульд сурч байгаа нийт 3, тусгай ажилтай 3, 64 алба хаагч хамрагдлаа. Үүнээс: Хэвийн жинтэй 57, 10кг-аас дээш илүү жинтэй 3, 1-9 кг илүү жинтэй 4 алба хаагч ажиллаж байна.

2020 оны 07 дугаар сарыг 2020 оны 7 дугаар сартай харьцуулсан үзүүлэлт



Аврагч-гал сөнөөгчийн өдөр тутмын сургалт:

Гал түймэр унтраах өдөр тутмын дасгал сургуулийг 1, 2, 3 дугаар схемээр байлдааны тархалт хийх, урьдчилан сунгасан 2 сунадаг шатаар гүйж сургалтын цамхгийн 3-р давхарт гарах, 2 сунадаг шатыг автомашинаас авч сургалтын цамхгийн 3 дугаар давхарт сунгаж гарах, араатай шатаар сургалтын цамхгийн 2, 4 дүгээр давхарт гарах, аврах олсоор эр, эм уяа зангидах, барилгын өндрөөс нэрвэгдэгсдийг аврах, автомашиныг усан сан дээр байрлуулж ус соруулах зэрэг төрлүүдээр 140 удаа 280 цагийн дадлагыг явуулж, давхардсан тоогоор 1960 алба хаагчийг хамруулснаар алба хаагчдын гал унтраах мэргэжлийн ур чадвар нэмэгдэж байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА,
ХУРАНДАА

М.АДЪЯАБААТАР

ТАЙЛАН БИЧСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ, БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ
СУРГАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ДЭД ХУРАНДАА

Б.МӨНХЖАРГАЛ

Маягт-СМ-2

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТЫН МЭДЭЭ

2020-11-17

д/д	Албаны сургалт						Мэргэжлийн сургалт					
	Офицер бүрэлдэхүүний сургалт			Ахлагч бүрэлдэхүүний сургалт			Төрөл мэргэжлийн аврагчийн сургалт			Тактик, тархалтын сургууль		
	Хэдэн удаа	Хэдэн цаг	Хамрагдсан хүн	Хэдэн удаа	Хэдэн цаг	Хамрагдсан хүн	Хэдэн удаа	Хэдэн цаг	Хамрагдсан хүн	Хэдэн удаа	Хамрагдсан техник хэрэгсэл	Хамрагдсан хүн
2020 оны 2 дугаар хагас	26	38	312	15	24	630	70	140	360	44	50	2392

МЭДЭЭ ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ, БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ
СУРГАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ДЭД ХУРАНДАА Б.МӨНХЖАРГАЛ